

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ 3 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2014 оны 3 дугаар сард 1 удаа хуралдаж 12 асуудал хэлэлцэн 16 тогтоол баталлаа.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, түрээсийн төлбөрийн хэмжээг шинэчлэн баталлаа.

УИХ-ын тамгын газар, НҮБ, Швейцарийн хөгжлийн агентлаг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, тэргүүлэгчид, ажлын албаны ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх сургалтыг 2014 оны 3 дугаар сарын 16-24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд аймаг, сумдын 400 гаруй төлөөлөгч хамрагдлаа.

ОХУ-ын Буриад улсын Ардын Хурлын дарга М.М.Гершевичийн урилгаар манай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 7-8 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл 2014 оны 03 дугаар сарын 11-14-ны өдрүүдэд Улаан-Үүд хотод ажлын айлчлал хийлээ.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Тус аймгийн Засаг С.Бүрэнбат тэргүүтэй ажлын хэсэг БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Эрээн хотноо 2014 оны 3 дугаар сарын 4-6-ны өдрүүдэд Эрээн хотын бүтээн байгуулалт, хот төлөвлөлтийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судалж,БНХАУ-ын Эрээн хотын зочид төлөөлөгчид манай аймагт 2014 оны 3 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд ажиллаж, хамтран ажиллах талаар аймгийн удирдлагуудтай санал солилцлоо. Уулзалтаар Сэлэнгэ аймагтай хот төлөвлөлт, ногоон байгууламжийг бий болгох, хоёр талын боловсролын салбар дахь хамтын ажиллагааг эрчимжүүлэн, Өвөр Монголын өөртөө засах орны Багшийн Их сургуулийн Эрээн хот дахь салбар сургуульд суралцаж буй Монгол оюутнуудад сургалтын төлбөрөөс 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх талаар хамтран ажиллахаар шийдвэрлэж, хоёр талын соёл ба аялал жуулчлалын талаар хамтын ажиллагааг эрчимжүүлэх, Бээжин-Эрээн-Монгол-ОХУ-Байгаль нуур чиглэлийн аялал жуулчлалын зорилтот маршрутыг нэвтрүүлэх талаар санал солилцлоо.

Төрийн жинхэнэ албанд анх удаа орох иргэдийн мэргэшлийн шалгалтын бүртгэлийг 2014 оны 3 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд, 11-12-ны өдрүүдэд шалгалтыг зохион байгуулж, шалгалтанд нийт дэс түшмэлийн 32, туслах түшмэлийн 18 ажлын байранд 280 иргэн өрсөлдөж, дэс түшмэлийн ангилалд 22, туслах түшмэлийн ангилалд 26 хүн тэнцэж, төрийн жинхэнэ албанд анх удаа орох нөөцийн жагсаалтад бүртгэгдэхээр боллоо.

Авлигатай тэмцэх газар, аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран аймгийн удирдах албан тушаалтнууд болон төрийн албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон хууль, эрх зүйн сургалтыг 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулан,сургалтанд төр, төсвийн байгууллагуудын төлөөлөл 130 гаруй хүн хамрагдлаа.

Аймгийн Засаг дарга С.Бүрэнбат 2-р сард аймгийнхаа зүүн чиглэлд байдаг застав, харуулын байруудаар явж, байгаа байдлыг нь газар дээр нь үзэж танилцсан бол 2014 оны 3 дугаар сард баруун чиглэл буюу тус аймгийн Түшиг сумын газар нутаг дээр байрлах Зэлтэр 2 дугаар застав, Баруун хужиртын 1 дүгээр застав, Хашаат байнгын харуулын байраар орж, байгаа байдлыг нь газар дээр нь үзэж танилцлаа. Аймгийн Засаг дарга хил дагуу амьдардаг айл өрхүүдийн хадлан тэжээл бэлдэх газар нутагт гарч байгаа гол зөрчил, маргааны шалтгаантай газар дээр нь үзэж танилцан, ойн хээрийн түймэр бусад чиглэлд сум орон нутаг, хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ажлаллаа.

Монгол Улсад шинэ үеийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 93 жилийн ой “Монгол цэргийн өдөр”-ийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэн, цэргийн болон цэрэгжсэн байгууллагуудын дунд “Мөрдөстөй бүсгүйчүүд”, “Би эр хүн” холын зайн гүйлт, “Тэргүүний дууч, жагсаалч салаа”, сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээн, ПМ гар буу, 7.62 мм-ийн АКМ автомат бууны мэргэн буудлага, Марш тактик тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг тус тус зохион байгууллаа.

Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн багийн Засаг дарга нарын “Баг-Иргэний засаг захиргаа” нэгдсэн сургалт, хэлэлцүүлгийг 2014 оны 3 дугаар сарын 25, 26-ны өдөр тус аймагт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран нийт Сэлэнгэ аймгийн 54, Дархан-Уул аймгийн 25 багийн Засаг даргыг хамруулан, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ш.Ганболд, Баян-Өндөр багийн Засаг дарга Ч.Дагвадорж нар Засаг захиргааны анхан шатны нэгж болох багаас үзүүлэх төрийн үйлчилгээний талаар Орхон аймгаас баримталж буй бодлого шийдвэрийн талаар мэдээлэл хийж туршлага судлалаа.

2014 оны 3 дугаар сарын 27-ны өдөр иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх “Иргэдээ сонсьё” ТВ-ийн шууд нэвтрүүлгийг орон нутгийн “Миний Монгол” КаТВ-тэй хамтран эрүүл мэндийн салбарын ажил үйлчилгээний талаар зохион байгуулж, аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв, Эм холбоо, Хувийн хэвшлийн эмнэлэгүүдийн төлөөлөл бүхий 40 гаруй эмч, мэргэжилтэн, ажилтнууд оролцож 30 гаруй санал, өргөдөл, гомдол, талархлыг хүлээн авч шийдвэрлэлээ.

Үндэсний цөөнх гэгддэг Казакийн ард түмний уламжлалт нарны баяр буюу Науризын баярын өдөр аймгийн Засаг дарга С.Бүрэнбат Жавхлант сумын Моностойн 2-р багийн иргэн С.Молдагорийн гэр бүлд зочилж Сэлэнгэ аймагт ажиллаж амьдарч буй казак түмний төлөөлөл болгон хүндэтгэл үзүүллээ.

Тайлант сард аймгийн Хууль сахиулах байгууллагуудын удирдлагуудын ажил хэргийн ээлжит уулзалтыг Шүүхийн Шинжилгээний албанд зохион байгууллаа.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

2-р сарын 28-ны байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн орлого	2399500.00	2359800.00	98.3
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	2072329.7	1997161.8	96.4
3	Орон нутгийн төсвийн зарлага	10693341.30	8521385.60	79.7
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага	1380135.10	887349.90	64.3
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт	307158.20	46815.80	15.2
	Авто замын хөрөнгө оруулалт	-	-	-
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1096000.00	1096000.00	100.0
5	Оёññí òõñääé ø èèæ;çèyã ò° ñâ° ñ î ëã ñî í çî ðèóèàèòù í	6388463.90	6388463.90	100.0
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	2427638.80	2427638.80	100.0

7	Засаг даргын нөөц	101520.00	68937.70	67.9
---	-------------------	-----------	----------	------

2014 оны төсвийн гүйцэтгэлийн 2 Үндэсний мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 98.3 хувь, улсаасавахсанхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 7.1 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 79.7 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 67.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2013 оны 2-р сар	2014 оны 3-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	900	900
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	800, 1800	800, 1800
3	Нарийн боов	1 кг	1800-2300	1800-2300
4	Элсэн чихэр	1 кг	2000	2000
5	Цагаан будаа	1 кг	2200	2200
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	7500	7500
7	Үхрийн мах	1 кг	9000	8500
8	Адууны мах	1 кг	7000	7000
9	Ямааны мах	1 кг	6500	6500
10	Дотор мах цувдай	1 кг	3500	3500
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	8000	8000
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				
12	Сүү /задгай/	1л	1100	1200
13	Сүү /савласан/	1л	1700-1800	2000
14	Тараг /задгай/	1л	1200	1000
15	Хорхой ааруул	1 кг	8000	8000
16	Айраг	1л	-	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4200	4200
18	Өндөг	ш	400	400
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2900-3500	2900-3500
20	Өөхөн тос	1 кг	1200	1200
21	Шар тос	1 кг	6000	6000
22	Масло /задгай/	1 кг	3000	3000
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс/Монгол/	1 кг	800	800
24	Лууван	1 кг	1000	1200
25	Манжин	1 кг	1500	2000
26	Байцаа	1 кг	800	1500
27	Сонгино	1 кг	2000	2000
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг	-	-
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст /даршилсан/ хэмх	ш	3200-4000	3200-4000

31	Алаг салат /даршилсан/	ш	2100-2500	1900-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1690	1700
34	Дизель түлш	1 л	1830	1830

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1. Архивын талаар:

Мандал сумын түүхт 90 жилийн ойн баярт зориулан гаргаж буй номонд оруулах зарим нэгэн түүхэн бичээстэй холбогдолтой баримтыг тус сумын хөмрөгийн 1960-2003 оны баримтуудаар батаглгаажууллаа.

Аймгийн төв Сүхбаатар суманд тавьсан хяналтын камерийн ажлын зураг төсөл, техникийн баримт бичиг,Тээврийг удирдах газар, “Жинчин” ХК–ий 1978-1998 оны санхүүгийн баримтыг хүлээн авч, хөмрөгт байрлууллаа.

Төрийн архивын баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийх ажлыг Алтанбулаг сумын хөдөө аж ахуйн техникумын 1954-1969 оны 15 хадгаламжийн нэгж, Орхонтуулынсангийн аж ахуйн 1972-1992 оны 187 хадгаламжийн нэгж, Энхталын сангийн аж ахуйн 1987-1992 оны 17хадгаламжийн нэгж, Ерөө сангийн аж ахуйн 1953-1991 оны 138 хадгаламжийн нэгж нийт 4 хөмрөгийн 357 хадгаламжийн нэгжид иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийжхадгалах хугацаа дууссан болон мэдээлэл, лавлагааны ач холбогдолгүй, эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх шаардлагатай, цахим хэлбэрт шилжүүлэх баримтуудыг олж илрүүлэх, тэдгээрт тус бүрд нь жагсаалт үйлдэх, тус хөмрөгийн дансны хадгаламжийн нэгжийн бүртгэлийн хэсгийг шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн дээрх нягтлан шалгалтанд хамрагдсан хөмрөгүүдийн дутсан баримтуудыг олж, тэдгээрийн шалтгааныг тогтоох ажлыг хийж гүйцэтгэх зорилгоор хэсэгчилсэн тооллогын ажлыг хийлээ.

Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд аймгийн Тээврийг удирдах газрын 1962-1989 оны 19 хадгаламжийн нэгжийн 2903 хуудас, Зүүнхараа хотын 42-р авто баазын 1975-1991 оны 23 хадгаламжийн нэгжийн 2836 хуудас буюу нийт 42 хадгаламжийн нэгжийн 5738 хуудас баримтыг сканерт оруулж мастер хувь үүсгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төрийн архивын АМС программд Алтанбулаг сангийн аж ахуйн хөмрөгийн 44 хадгаламжийн нэгжийн 8536 хуудас баримтыг баримтын мэдээлэлтэй холбох ажлыг хийлээ. Мастер хувиас Зүүнхараа сангийн аж ахуйн хөмрөгийн 18 хадгаламжийн нэгжийн 4111 хуудас баримтыг Photoshop программ ашиглан ашиглалтын хувь үүсгэлээ.

Иргэд, албан байгууллагын гаргасан хүсэлтийн дагууархивын хуулбар 239, цалингийнтодорхойлолт 9, магадлагаа 43, тодорхойлолт 48, эхийн одонгийн лавлагаа 3гаргаж үйлчиллээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсролын чиглэлээр:

Аймгийн Боловсролын газраас 2013-2014 оны хичээлийн жилийн явцтай танилцан, зөвлөн туслах зорилгоор 2014 оны 3-р сарын 3-7-ны өдрүүдэд Хараа бүсийн ерөнхий боловсролын 8 сургууль, 7 цэцэрлэгт зөвлөн туслах багийг ажиллуулж, сургалтын үйл явц, сургалтын анги, дотуур байрны эрүүл ахуй, ариун цэврийнбайдалд хяналт шалгалт хийж, сургалт зохион байгуулж, боловсролын үйлчилгээний сэтгэл ханамжийн талаарх судалгааг нийт 350 багш, 250 сурагч, 300 гаруй эцэг эхчүүдээс авлаа.

Мандал сумын 3 дугаар сургуулийн захирал, Хэрх тосгоны цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байранд сонгон шалгаруулалтыг 2014 оны 3-р сарын 20-ныөдөр

Тайлант сард зөвлөн туслах ажлыг “Хас банк”, “Голомт банк”, “Миг даатгал”, Сүхбаатар сумын 2, 4-р цэцэрлэг зэрэг аж ахуйн нэгж, байгууллагуудад гүйцэтгэж 2012-2013 оны цалин ба түүнтэй адилтгах орлогын нийгмийн даатгалын шимтгэлийн ноогдуулалт, төлөлтөнд хяналт, шалгалт хийхэд зөрчил гараагүй болно.

4. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 3085 иргэнд 964559.2 мянган төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1124 иргэнд 148524.1 мянган төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 404 иргэнд 114165.4 мянган төгрөг, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж 880 иргэнд 120728.5 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 120 иргэнд 33418.0 мянган төгрөг, Эхийн алдар одонтой 8374 эхэд 1152800.0 мянган төгрөгийн тусламжийн голголоо.

Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2854 эхэд 340775.1 мянган төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 43 иргэнд 24930.0 мянган төгрөг, банкны үйлчилгээний шимтгэлд 1857.8 мянган төгрөгийг олгоод байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг угтан 15 сум 6 тосгондаймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсээс “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 650 эмэгтэй хамрагдлаа.

5. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2014 оны 2-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 853 хүн байсан бол 27 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 42 ажлын байранд 35 хүнийг ажилд зуучилж ажилгүйчүүдийн тоо 845 боллоо.

Тайлант сард аймгийн Хөдөмөрийн хэлтсээс сумдын Засаг дарга, хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд “Зээлийн батлан даалтын сан”-гийн талаар сургалт зохион байгууллаа.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 2,4-р сургуулийн 9,10,11-р ангийн 142 сурагчдад “Мэргэжил бүхэн сайхан” сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөрийн хэлтэс хамтран Мандал, Сант, Шаамар, Сүхбаатар сумдын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд хяналт шалгалт хийлээ.

“Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдээс 2013 оны 4-р улиралд нийт 247 төгсөгч төгссөнөөс 103 төгсөгч ажлын байранд зуучлагдан ажиллаж байна.

6. Хүүхэд залуучуудын талаар:

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэст хүүхэд, гэр бүлийн санал хүсэлтийг сонсох “Хүүхэд хамгаалал”-ын 95491979 хүүхдийн утсыг ажиллуулж эхэллээ.

2014 оны 03 дугаар сарын 05-ны өдөр аймгийн Насан туршийн боловсрол олгох төвийн 11 суралцагчдад “Үе тэнгийнхний шахалт дарамт, түүний илрэх хэлбэрийн талаар мэдээлэл өгч, дарамт шахалтыг аливаа шаардлагаас ялгах, шахалт дарамтаас зайлсхийх чадвар эзэмшүүлэх” сургалтыг зохион байгууллаа.

2014 оны 3 дугаар сарын 9-ний өдөр Олон улсын Хүүхдийн нэвтрүүлгийн өдрийг аймгийн хэмжээнд “Бид эх дэлхийн цэцэгс, бид эх орны ирээдүй” уриан дор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс “Таны Сэлэнгэ” КаТВ-эй хамтран зохион байгуулж, Сүхбаатар сумын 1, 7 дугаар цэцэрлэгийн авьяаслаг багачуудын урлагийн тоглолт, оны шилдэг хүүхдийн номинацид шалгарсан сурагчид оролцсон “Амжилтын эзэд” нэвтрүүлэг, Хүүхдийн ордны морин хуурын дугуйлангийн хүүхдийн танилцуулга нэвтрүүлгийг тус тус бэлтгэн гаргалаа.

Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Хилийн цэргийн 0243-р ангийн эмэгтэйчүүдэд “Гэр бүлийн харилцаа, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Хүүхдийн оролцоо эрүүл мэнд, боловсрол” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, Сүхбаатар, Шаамар сумдын 40 орчим хүүхэд хамрагдлаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газраас нийт газар тариалан эрхлэгчдэд зориулж “Газар тариалангийн техник, технологи”-ийн сургалтыг Баянгол, Сайхан, Орхон, Баруунбүрэн, Жавхлант, Ерөө, Цагааннуур сумдад зохион байгуулж, сургалтанд нийт 160 гаруй механикжуулагч хамрагдлаа.

Агуйн хөдөө аж ахуйн газраас нийт газар тариалан эрхлэгчдэд зориулж “Газар тариалангийн техник, технологи”-ийн сургалтыг Баянгол, Сайхан, Орхон, Баруунбүрэн, Жавхлант, Ерөө, Цагааннуур сумдад зохион байгуулж, сургалтанд нийт 160 гаруй механикжуулагч хамрагдлаа.

Агуйн хөдөө аж ахуйн газраас нийт газар тариалан эрхлэгчдэд зориулж “Газар тариалангийн техник, технологи”-ийн сургалтыг Баянгол, Сайхан, Орхон, Баруунбүрэн, Жавхлант, Ерөө, Цагааннуур сумдад зохион байгуулж, сургалтанд нийт 160 гаруй механикжуулагч хамрагдлаа.

Агуйн хөдөө аж ахуйн газраас нийт газар тариалан эрхлэгчдэд зориулж “Газар тариалангийн техник, технологи”-ийн сургалтыг Баянгол, Сайхан, Орхон, Баруунбүрэн, Жавхлант, Ерөө, Цагааннуур сумдад зохион байгуулж, сургалтанд нийт 160 гаруй механикжуулагч хамрагдлаа.

Агуйн хөдөө аж ахуйн газраас нийт газар тариалан эрхлэгчдэд зориулж “Газар тариалангийн техник, технологи”-ийн сургалтыг Баянгол, Сайхан, Орхон, Баруунбүрэн, Жавхлант, Ерөө, Цагааннуур сумдад зохион байгуулж, сургалтанд нийт 160 гаруй механикжуулагч хамрагдлаа.

Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:

1. Газрын харилцааны талаар:

Сант, Орхон сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газруудыг зураг дээр буулгаж, ArcGis программ дээр мэдээллийн санг үүсгэн тоон стандартын дагуу боловсрууллаа.

Аймгийн хэмжээнд улсын чанартай авто замууд, орон нутгийн чанартай авто замуудын уулзвар, гүүр, суурин газруудын байршил, аялал жуулчлал, хүн амын очих сонирхол бүхий газруудын байршил зэргийн тоог гаргаж зурагт тэмдэглэж Газрын харилцаа, геодези зураг зүйн газарт хүргүүлээ.

Газрын харилцааны албан хэрэгцээнд ашиглагддаг программ хангамж шинэчлэгдэж “Land Manager” программыг нэвтрүүлэх болсонтой холбоотой Сүхбаатар суманд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын бүх мэдээллийг мэдээллийн баазад оруулж дуусгах зорилгоор тайлант сард 120 нэгж талбартай холбоотой хувийн хэргийн мэдээллийг уг програмд шивж орууллаа.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 28 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж баталгаажууллаа.

2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:

Шинэ сумын төв төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумыг сонгон ажиллажбайгаа бөгөөд тус ажлын зургийндаалгавар, Мөрөөдөл, залуус хотхоныг

Аймгийн прокурорын газар, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 30 гаруй иргэн хамрагдлаа.

6.1 àí ääë ñòì :

Аймгийн Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг тус суманд 2014 оны 3 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Тус сумын хүүхэд хамгааллын хамтарсан баг 3 удаа хуралдаж, 1 хүүхдийг цэцэрлэгт, 1 хүүхдийг сургуульд хамруулан, хүүхдүүдийн авьяас чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Дунгийн эгшиг”, “Уран жиргээ” зэрэг тэмцээн, “Би эстрадын дуучин” аймгийн дууны их наадмыг зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, нэгдсэн эмнэлэг, цагдаагийн хэлтэс хамтран “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт 73 эмэгтэйчүүдийг хамруулан санал, бодлоо солилцож, сумын “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийг байгууллаа.

7. Орхон сум:

2014 оныг тус аймаг “Ээлтэй орчин, их бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогду Орхон сумын Засаг даргын Тамгын газраас иргэдийн дунд хийж, хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж шийдвэрийн хүрээнд сумын Засаг даргын 2014 оны Б/15 тоот захирамжаар байгууллага сурталчлах 14 хоногийн аяныг зарлаж, зохион байгууллаа.

Сумын Засаг даргын 2013 оны А/28 тоот захирамжаар батлагдсан сар бүрийн 4-р долоо хоногийн “Тайлан- мэдээлэл, санал-шийдэл” нэрэмжит өдрөөр төр төсвийн байгууллагуудын ажилтан, албан хаагчид болон ард иргэдэд халамжийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэрийг сурталчилж 67 иргэнийг хамрууллаа.

Мөн зарласан жилийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газраас нийт ард иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн дунд “Мянган цэцгийн баяр” аяныг өрнүүлж, айл өрх, албан байгууллагын гадна болон дотоод тохижилт, соёлжилтыг сайжруулах, тасалгааны цэцэг болон цэцгийн мандлын төрөл, тоог олшруулан сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, ард иргэдийн амьдрах таатай орчныг бий болго зорилгоор 2014 оны 3-р сарын 1-ний өдрөөс 2014 оны 6 сарын 1-ний өдрийг хүртэл зарлалаа.

2014 оны 3-р сарын 15-ны өдөр Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит орос, англи хэлний “Бага олимпиад”-ыг Орхон бүсийн 9 сургуулийн нийт 140 гаруй сурагчдыг хамруулан амжилттай зохион байгууллаа.

Эх хэлний арвин баян сангаас уран яруу үг хэллэгээр илэрхийлж, үндэсний хэл соёлоороо бахархах, хэл ярианы баялгаа нэмэгдүүлж унших, бичих чадварыг сайжруулан хүүхэд бүрийн авьяас билгийг нээн илрүүлж хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Орхоны яргуй-2014” өсвөрийн яруу найргийн наадам 2014 оны 2-р сарын 28-нд 18 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

8. Орхонтуул сум:

Орхонтуул сумын “Эдийн засаг, нийгмийг 2010-2025 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөө”-г тус сумын Засаг даргын Тамгын газраас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, төр, төсвийн байгууллагуудын ажилтан албан хаагчдын албан хэрэгцээнд зориулан ном болгон хэвлүүллээ.

Орхонтуул сумын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2014 оны 3-р сарын 20-ны өдөр тус сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж, 2013 онд зохион байгуулсан ажил арга хэмжээний ажлын алдаа, дутагдал, ололттэй тал, цаашид авах арга хэмжээний тухай болон 2014 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн томоохон бүтээн байгуулалтын ажлынталаар мэдээлэл хийлээ. Тус зөвлөгөөнөөс

сумын төрийн албан хаагчдын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах талаар зөвлөмж гарган нийт төрийн албан хаагчдад хүргүүлээ.

Сумын Засаг даргын Тамгын газар нь 2014 оныг “Ээлтэй орчин, иргэн төвтэй үйлчилгээ”-ний жил болгон зарлаж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор “Мэдээллийг иргэн бүрт” арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Рашаант тосгоны Захирагчийн алба хамтран Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт” сэдэвт хэлэлцүүлгийг сумын төв, Рашаант тосгонд зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст хүргүүлээ.

9.Сант сум:

Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газраас малчдын зөвлөлгөөнийг зохион байгуулж 108 малчин хамрагдан, Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар сумын Засаг дарга малчдад мэдээлэл хийн, үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, хонины ноос тэмээний ноос бэлтгэн үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам, хоршоо байгуулах аргачлал, хоршоо байгуулахад бүрдүүлэх баримт бичиг, бэлчээр зохион байгуулалт, малчид хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, малчдын хөдөлмөр эрхлэлтийн тухай, малчдыг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгэх тухай, гоцхалдвартгалзуу, шүлхий өвчинтэй тэмцэх тухай сэдвүүдээр гарын авлага материал тараан, зөвлөлгөөнөөс нийт 9 заалттай уриалга зөвлөмж гарган ажиллаж байна.

Сант сумын Засаг даргын 2014 оны А/08 тоот захирамжаар батлагдсан “Хог хаягдал, тохижилт, ногоон байгууламж” сэдэвт 3 сарын аяныг тус сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж, айл өрхийн эзэмшил 40 га, сумын нийтийн эдэлбэр 15 га газрыг цэвэрлэх ажилд Ивэн, Хушаат багийн иргэд болон тус суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагуудын албан хаагчид нийт 395 хүн хамрагдаж, 164м³ хогийг цэвэрлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас /Хүнсний аюулгүй байдал хариуцсан орон тооны бус зөвлөл/ 4 төсөвт байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын хоол хүнсний чанар, аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүний хадгалах орчин, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, бусад дагалдах баримт бичгийн мөрдөлтөнд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгууллаа.

Сант сумын эрүүл мэндийн төвөөс “Сүрьеэ өвчнөөс сэргийлэх, түүний дамжих зам, хэрхэн сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 78 иргэн хамрагдлаа.

10.Сайхан сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар, сумын хууль хяналтын байгууллагуудтай хамтран ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 9-11-р ангийн 15 бүлгийн 406 сурагчдыг хамруулан, “Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

2014 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Сайхан сумын Засаг даргын Тамгын газар, сумын Эмэгтэйчүүдийн холбоо, орон нутгийн “Эрдэнэ” КаТВ-тэй хамтран Сайхан сумын “Ажил хэрэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-ыг зохион байгуулж, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт” хэлэлцүүлгийг явууллаа.

Сайхан ерөнхий боловсролын сургуульд “Шүд, гараа угааж хэвших нь эрүүл байхын үндэс” аяныг зохион байгуулж, сурагч нэг бүрийг шүд, гараа зөв угаадаг дадал хэвшилд сурган, нийт 22 бүлгийн 680 гаруй суралцагчид хамрагдлаа.

Аймгийн 100 буудалт даамны аварга шалгаруулах тэмцээнийг Хөтөл ерөнхий боловсролын сургууль дээр 2014 оны 3-р сарын 22-ны өдөр зохион байгууллаа.

Тус сумын соёлын төв, эмэгтэйчүүдийн холбоотой хамран Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “Хөтөлийн сайхан залуу”, “Хөтөлийн сайхан бүсгүй” уралдаант шоутэмцээнийг зохион байгууллаа.

Тайлант сард тус сумын Эрүүл мэндийн төвөөс “Эрчүүдийн эрүүл мэнд-Эх орны хийморь” сэдэвт 10 хоногийн аян зохион байгуулж, эрэгтэй төрийн албан хаагчдыг үзлэг, шинжилгээнд хамрууллаа.

Аймгийн 42 мал эмнэлгийн үржлийн нэгжүүдийн захирал, мэргэжилтний уулзалт семинарыг тус суманд зохион байгуулж, 2013 оны ажлаа дүгнэн, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэн, 2014 оныг “Эмчийн ёс зүйг дээдэлж, эрүүл мэндийг сахин хамгаалах жил” болгон зараллаа.

11.Сүхбаатар сум:

2014 оны 3 дугаар сарын 6-ны өдөр “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт” сэдэвт хэлэлцүүлгийг аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгууллаа.

Сүхбаатар хотын Тохижилт үйлчилгээний газрын нийт ажилтнуудын дунд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Сүбхаатар сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн сургалтыг зохион байгууллаа.

Тус сумын 12 жилийн 6-р сургуульд Койко олон улсын байгууллагын боловсролын хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 39.0 сая төгрөгийн өртөг бүхий мэдээлэл зүй, компьютер сургалтын “Гэгээн хүслэн” төвбайгуулагдан нээлтээ хийлээ.

12.Алтанбулаг сум:

Тус сумын Засаг даргын ивээл дор сумын Засаг даргын Тамгын газар, эмэгтэйчүүдийн холбоо хамтран “Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чуулга уулзалт”-ыг зохион байгууллаа.

Тус сумын нутаг дэвсгэрийн Цэнхэрийн булан, сумын төвийн Солдат толгойн урд хэсэг, Сэлэмтийн зүүн хэсгээр бүгд 20 иргэнд 20.268 сая төгрөгийн үнэ бүхий 2.83 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд зориулж үнэ төлбөргүйгээр өмчлүүлээ.

2014 оны 3 дугаар сарын 5, 21-ний өдрүүдэд сумын Засаг даргын Тамгын газраас “Монгол бичиг 2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор тус сумын төр, төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчдын дунд Монгол бичгийн олимпиадыг зохион байгууллаа.

Тус сумын ерөнхий боловсролын сургууль, Түшиг сумын ерөнхий боловсролын сургуультай хамтран “Хичээлээр хүүхдийг хөгжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт хичээлийг зохион байгуулж бага ангийн Монгол хэл, дунд ангийн Англи хэлний хичээлийг хамтран зааж хэлэлцүүлэг өрнүүлээ.

13.Цагааннуур сум:

2014 оны 03 сарын 17-ны өдөр Огнооноос Эх өдөрөөр Ажлын үндэсний туслах үйлдлийн төлөвлөгөөнийг хэрэгжүүлэх зорилгоор тус сумын төр, төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчдын дунд Монгол бичгийн олимпиадыг зохион байгууллаа.

Тус сумын Засаг дарга 2014 оны 3 сарын 18-ны өдөр иргэд, хөдөлмөрчидтэй уулзалт зохион байгуулж, өөрийн үйлдлийн төлөвлөгөөнийг хэрэгжүүлэх зорилгоор тус сумын төр, төсвийн байгууллагуудын төрийн албан хаагчдын дунд Монгол бичгийн олимпиадыг зохион байгууллаа.

Цагааннуур сой үй Цагаан ааддүй 2014 ийү А/15 ойиò çàòèòàì æар “Сумын иòàà àуáñàуòò оиòèæèèò, ииá ии áàèæòòèàì æèèиòàèààò èòáуá, àèè °òò, àæ àòòèи нэгж, байгууллагууд дагаж мөрдөх журам”-и áààòèààà áàèи à.

Аèи æèèи Пòи èòòиòи áàçàò, Оàæàààæèèи áàçàò, тус сумын Засаг даргын Тамгын газар òàìòòàì иргэдэд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сэдэвт ñòðæèèòù æ2014 оны 3-ò ñàòòи 13-и ү ° ä° ð зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас “Ой хээрийн түймэр”-ээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх санамж бичгийг 450 иргэнд тараан түймэр гаргахгүй байх гарын үсгийн баталгааг гарган авлаа.

14.Хушаат сум:

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Эмэгтэйчүүдийн холбоо хамтран Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан сумын малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн, үсчин, гоо сайхны зэрэг үйлчилгээнд малчин эмэгтэйчүүдийг хамруулан урлагийн тоглолт, караоке үдэшлэг зохион байгуулж 80 гаруй малчид хамрагдлаа.

Зэвсэгт хүчин байгуулагдсаны 93 жилийн ойд зориулан Хушаат сумын Засаг даргын Тамгын газар, Соёлын төвөөс сумын эрчүүдийнхээ зориг тэвчээр, хүч чадлыг сорьсон “Би эр хүн” тэмцээнийг 8 төрлөөр зохион байгуулж, туссумын эрүүл мэндийн төвөөс эрэгтэй төрийн албан хаагчдыг 7 хоногийн турш эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Архи тамхигүй сум” жилийн аянг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, сумын Засаг даргын захирамжаар 2014 оны 3-р сарын13–ны өдөр “Архи тамхигүй сум” аяны нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсэг, багийн Засаг дарга нар хамтран сумын малчин өрхүүдийн нийгмийн даатгалын үйлчилгээ, тээврийн хэрэгсэл, галт зэвсэгтэй иргэдийн судалгааг аван мэдээллийн бааз үүсгэлээ.

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Монгол төмс” хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр суманд “Байцааны үрслэг бойжуулах төв” байгуулах талаар ногоочдын дунд 2 удаа сургалт зохион байгуулж, 17 сая төгрөгийн “Байцааны үрслэг бойжуулах төв” байгуулах гэрээ хийлээ.

15.Хүдэр сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас сумын засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2013 оны тайланг иргэдэд хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 90 гаруй иргэд оролцлоо.

Тус сумын Эрүүл мэндийн төвөөс “Томуу өвчнөөс сэргийлье”сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сурагчид, эцэг эхчүүднийт 74 хүнийг хамруулан зохион байгууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор тус сумын Засаг даргын Захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Модны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжжүүдэд хяналт шалгалтын ажлыг хийж байна.

2014 оны сумын Засаг даргын А/08 тоот захирамжийн дагуу тус суман дахь мод бэлтгэлийн ажлыг зогсоож, мод бэлтгэлийн талбайг 3-р сарын 23-ны дотор сумын ойн анги, байгаль хамгаалагч, тухайн ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлд цэвэрлэгээг хийж, хүлээлгэн өлөө.

16.Шаамар сум:

Тус сумын ерөнхий боловсролын сургуулиас “Хамтдаа суралцъя”аяны хүрээнд хүүхэд багачуудыг тоглоом наадгайгаар хүмүүжүүлэх, ардын ухааныг өвлүүлэх, хүүхдийг төлөвшүүлэх, ёс зашлыг өвлүүлэх зорилгоор 3-5 дугаар ангийн сурагчдын дунд “Би монгол хүүхэд” ёс заншлын баярыг зохион байгууллаа.

Аймгаас 2014 оныг "Ээлтэй орчин-Их бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбогдуулан тус сумын 90 жилийн ойг угтан хийх бүтээлч ажлын 3 сарын аяныг сумын хэмжээнд зохион байгуулж байна.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Түүхт-Шаамар төрийн бус байгууллагатай хамтран сумын ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийнхэн Улаанбаатар хот, Булган, Орхон, Дархан-Уул аймаг дахь нутгийн зөвлөлтэй хамтран ажиллах, уулзалт зохион байгуулах ажиллагааг 2014 оны 3-р сарын 27-ны өдрөөс эхлүүлээд байна.

Ойн хуулийн хэрэгжилтэнд 6 удаа, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэнд 1 удаа, Усны тухай хуулийн хэрэгжилтэнд 2 удаа сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Мэргэжлийн хяналтын газар хамтран хяналт шалгалт хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр нийт 3 иргэнд 9 сая төгрөгийн зээл олгож, зээлэнд хамрагдсан иргэдийг шинэ ажлын байранд бүртгэж мэдээллийн санд баяжилт хийлээ.

17.Түшиг сум:

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 тоот тогтоолоор сумын түүхт 90 жилийн ойн арга хэмжээг 2014 оны 7 сарын 17, 18-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрллээ.

Сум байгуулагдсаны ойгоо угтаж тус сумын Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран "Түшиг түмэн" хүндэтгэлийн арга хэмжээг 2014 оны 3-р сарын 13-ны өдөр зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 2014 оны 3-р сарын 12-нд нутгийн удирдлагын холбооны сургалтанд хамрагдаж, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хангарьд ордны үйл ажиллагаатай танилцлаа.

Найм.Бусад ажлын талаар:

Онцгой байдлын газар:

Аймгийн Онцгой байдлын газарт аврах ажлын багаж хэрэгсэлд 41.1 сая төгрөг, усны хувцас хэрэглэлд 7.7 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргаар шийдвэрлүүлээ.

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай" А/84 тоот захирамж гарч, хэрэгжилтийг, хангаж 2014 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд ойн дагалт баялаг ашиглах, ойд аялах, зугаалах, ан хийх, бугын эвэр түүх, мод бэлтгэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд түрзогсоосон.

Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах чиглэлээр аймгийн Засаг даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/79 дүгээр захирамж гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургалтыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө", "Зарлан мэдээлэх дохио дамжуулах дадлага сургууль"-ийг зохион байгуулах аймгийн Засаг даргын захирамжаар 2014 оны 3 дугаар сарын 27-ны өдөр дадлага, сургалтыг зохион байгууллаа.

Монгол Улсын Шадар сайдын баталсан "Төрийн ордон, засгийн газрын байрууд, улсын онц чухал объектууд, төрийн захиргааны байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын удирдамж"-ийн биелэлтийн шалгалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан "Үзвэр

үйлчилгээ, соёл урлагийн байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах” төлөвлөгөөт шалгалтын удирдамж, Онцгой байдлын газрын даргын баталсан “Орон сууцны барилгын нэг болон зоорийн давхарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад гамшгаас хамгаалах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт шалгалт”-ын биелэлтийн шалгалт, “Гэр хорооллын айл өрхийн цахилгааны галын аюулгүй байдал” нэгдсэн арга хэмжээний удирдамжуудын хүрээнд 155 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 98 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 44, мэдэгдэл 22, хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 6 аж ахуйн нэгж, байгууллагыг 550.0 мянган төгрөгөөр, 1 албан тушаалтныг 40 мянган төгрөгөөр торгож нийт 590.0 мянган төгрөгийн захиргааны арга хэмжээ ногдуулсан.

Биелэлтийн шалгалтад хамрагдсан 47 байгууллагын илэрсэн зөрчлийг арилгасан байдлыг авч үзвэл 385 зөрчил илэрсэнээс биелэлтийн шалгалтанд 298 зөрчил арилж 77.4 хувийн биелэлттэй байна. Бусад зөрчлийг арилгуулахаар 12 мэдэгдэл үйлдэж аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн.

Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Тээвэр авто замын газар хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийтийн тээвэр, такси үйлчилгээний нийт 18 аж ахуйн нэгжүүдийн холбогдох ажилтнуудыг хамруулан “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2011”, “MNS 5122:2013 такси үйлчилгээ, “Ерөнхий шаардлага” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Сүхбаатар суманд зохион байгуулсан хэмжих хэрэгслийн тооллогын дүнг үндэслэн аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Нэгдсэн эмнэлэгт байгууллагынхаа хэмжээнд хэмжил зүйн ажлын зохион байгуулалтыг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлээ.

Сайхан сумын “Гавшгай ус” ХХК-ий бохир ус цэвэрлэх байгууламжид “Цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага- MNS 4288:1995” стандартын дагуу аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний алба, Байгаль орчны газар, Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс хамтран үнэлгээ хийлээ.

Дэлхийн усны өдөрт зориулан “Усаа хэмнэе” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 7 хоногийн хугацаатай зарлаж, уралдаанд нийт 71 сурагч эссэ бичлэгээрүүлснээс 5 сурагч 1, 2, 3-р байрт шалгарч, 6 сурагчийн эссэг тусгай байрт шалгаруулан, 1-р байрт шалгарсан эссэ бичлэгийг орон нутгийн “Сэлэнгийн мэдээ” сонинд нийтлүүлээ.

Аймгийн Засаг даргын орлогч Н.Батдоржоор ахлуулсан Баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн ээлжит хурлаар 10 худалдаа үйлчилгээний газарт хийсэн тохирлын үнэлгээний дүнг хэлэлцэж, 8 үйлчилгээний газруудад “Тохирлын гэрчилгээ”-г 1-2 жилийн хугацаагаар олгох, хугацааг сунгах, 2 худалдаа үйлчилгээний газарт үл тохирол хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

6 сум, 1 тосгоны 47 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийснээс 30 аж ахуйн нэгжид тохирлын гэрчилгээ олголоо.

Сүхбаатар, Ерөө, Цагааннуур, Сайхан, Баруунбүрэн сумын 10 аж ахуйн нэгж, иргэний 7 нэрийн 20 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргалаа.

Худалдаа үйлчилгээний 11 байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд аргазүйн зөвлөгөө өгч 11 нэрийн 16 стандартаар хангах үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар, Мандал сумын худалдаа үйлчилгээний газруудад ашиглагддаг 50 жин, 4-нарийн хэмжүүрт ээлжит баталгаажуулалт хийлээ.

Цахилгааны 1 фазын 25 механик тоолуурыг ээлжитбаталгаажуулалтанд хамрууллаа.

Мензурка 3ширхэг, усны тоолуур2ширхгийг баталгаажуулан, 2 ШТС-ын 6 түгээгүүрт баталгаа хийлээ.

“Урсгал Ус” ХХК-тай хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын гэрээ хийлээ.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР